



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 12 өдөр

Дугаар A/208

Батширээт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.8, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэр болох Ононгийн Халуун рашаан, Онон баг, Барх багуудын нутаг дэвсгэрт эргүүл шалгалтыг 2025 оны 12 сарын 13-наас 2025 оны 12 сарын 25-ны хооронд зохион байгуулсугай.

2. Байгаль орчны хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Төрмөнх – Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Мөнх-Очир - Байгаль орчны хяналтын улсын
Байцаагч

Г.Гантуяа – Сум дундын Ойн ангийн дарга

Т.Санчир – Хэсгийн төлөөлөгч

Б.Тулга – Байгаль хамгаалагч

3. Ойн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу эргүүл шалгалтыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

4. Холбогдох зардлыг Сумын гамшгийн эрсдэлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Цолмон)-д даалгасугай.

ДАРГА



БАЛТАНГЭРЭЛ

232501411